

Сангийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 125 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮННИЙ САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.

**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 80'000'000 хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар шалгаруулахад мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн ажлыг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах ажил буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn



Огноо: 2020.03.17

**ЗАВХАН АЙМГИЙН ИДЭР СУМАНД ОЙЖУУЛАЛТ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ
АЖЛЫН ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр:

Гэрээний дугаар:

Завхан аймгийн Идэр суманд ойжуулалт, ойг нөхөн
сэргээх ажил

09-XA-12/2020

Захиалагч:

ЗАВХАН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Улиастай сум 2020 он

БАТЛАВ:

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА**

Д.БАТМЭНД

Огноо: 2020.04.15

**ЗАВХАН АЙМГИЙН ИДЭР СУМАНД ОЙЖУУЛАЛТ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ
АЖЛЫН ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр:

**Завхан аймгийн Идэр суманд ойжуулалт, ойг нөхөн
сэргээх ажил**

Гэрээний дугаар:

09-ХА-12/2020

Захиалагч:

ЗАВХАН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Улиастай сум 2020 он

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендериийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендериийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендериийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендериийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендериийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендериийн үнэ**
 - 4.1. Тендериийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтаасан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендериийн нийт үнэд багтаасан байна.

-
- | | |
|--|--|
| 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 6. Алдааг залруулах | 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна: <ul style="list-style-type: none">(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна. |
| | 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТӨӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>ЗАВХАН АЙМАГИЙН ИДЭР СУМАНД “ОЙЖУУЛАЛТ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ” АЖИЛ Дугаар 09-ХА-12/2020</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээ болон Тусгай зөвшөөрлийн эх хувийг гэрээний хамт хувилж, Тендер зарласнаас хойши хугацаанд нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. 2. Тендерт оролцогч нь Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага хяналт шинжилгээний системээс тендерт оролцогчдын татвар төлөлт, борлуулалтын орлого, ашиг зэрэг мэдээллийг шалгана. 3. Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: “Мод үргүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх” чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй байх. 4. Харьяа татварын алба болон нийгмийн даатгалын газраас өр, авлагын талаар тодорхойлолт авч тендерт хавсаргаж ирүүлнэ. Тодорхойлолтуудын хугацаа нь тендерт зарласан өдрөөс хойш байна. Шаардлагатай гэж үзвэл захиалагч тендерт оролцогчийн татвар, НДШ төлөлтийн мэдээллийг холбогдох татвар, НД-ын байгууллагаас тендерийн нээлт хийсэн өдрөөр тодруулга авна. 5. Захиалагч татвар, НД-ын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. 6. НД-ын шимтгэл төлөлтийн НД 7,8 тайланг тендер нээх хугацаанаас өмнөх 2020оны 1,2-р сарын тайланг хавсаргаж ирүүлнэ. 7. Харилцагч банкнаас тодорхойлолт ирүүлнэ. Захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ. 8. Харьяа шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг ирүүлнэ. 9. Ойжуулалт болон адил ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил- 2018, 2019 онууд Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний үүргийн биелэлтийг захиалагчийн техник, хяналт хийсэн хуулийн этгээдээс өгсөн тодорхойлолтыг ирүүлэх. 10. Борлуулалтын хэмжээ: [Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онууд] Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртөгийн 50%-иас багагүй байна. 11. Хуримтлагдсан ашиг алдагдал нь : Ашигтай ажилласан байх жилийн тоо: [Сүүлийн 2 жил 2018, 2019 онуудад] 12. Инженер техникийн ажилтан нь ойд цэвэрлэгээ хийж байгалийн сэргэн ургалтад туслах ажил буюу үүнтэй ижил төстэй гэрээг бие даан хариуцаж ажилласан 3 жилийн туршлагатай байх. Нотлох баримт бичиг ирүүлэх.

	<p>13. Ойжуулалтын ажил хийхэд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинтэй байх. Мэргэжлийн боловсон хүчний диплом, мэргэжлийн үнэмлэх, ажилд орсон тушаал, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлэх. /Ойн инженер гэх мэт/</p> <p>14. Тендерт оролцогч ойжуулалтын ажилд шаардлагатай ажлын багаж хэрэгсэл, авто машин түрээслэх гэрээ, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нотлох баримт бичиг, жагсаалтыг ирүүлэх.</p> <p>15. Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, ажлын төсөв, үе шатны ажлын хуваарь</p> <p>16. Техникийн тодорхойлолтонд дүйцэхүйц байна.</p> <p>17. Ойжуулах ажилд шаардагдах шаардлага хангасан стандартын тарьцны нөөцтэй байх. Стандартын шаардлага хангасан нотлох баримт, тодорхойлолт ирүүлэх.</p> <p>18. Тендерийн баримт бичигт тусгагдсан гэрээний Ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>19. Дотоодын давуу эрхийн зөрүү: [тооцно] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг хамгийн их ажиллах хүч авсан бол давуу эрхийн зөрүү тооцно. /Давуу эрх тооцуулахыг хүссэн оролцогч нотлох баримтыг хавсаргана. /Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа аж ахуй нэгжүүдтэй байгуулсан гэрээ, бараа материалын стандартын шаардлага хангаж буйг илэрхийлсэн тодорхойлолт, удирдах ажилтны тушаалаар томилогдсон ажилчдын жагсаалт, гэрээ, холбогдох бусад бичиг баримт. Мөн дотоодын давуу эрхийг тооцуулах хүсэлтээ албан бичгээр өгөх.</p>
ТОӨЗ 2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрж цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг http://www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: [2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр] Цаг: [10 цаг 30 минут]</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: [Завхан аймгийн Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба] Давхар болон өрөөний дугаар: [4-р давхар №417 тоот] Аймаг, хот: [Завхан аймаг Улиастай хот] Шуудангийн дугаар: [байхгүй] Улс: [Монгол Улс] Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: [2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр] Цаг: [11 цаг 00 минут]</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтыг бэлтгэх санамж

Товч бөгөөд тодорхой бэлтгэгдсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн, эсхүл орчин үеийн загварын, зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардах ёстой.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай байдаг. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн бараа, ажлын стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн ижил бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Авто зам, усан зогсоол, төмөр зам, орон сууц, усжуулалт, усан хангамж гэх зэрэг дэд бүтцийн салбаруудад тухайн бүс нутгийн ижил төстэй нөхцөлд давтагдаж хийгдэх ажлуудад стандарт ерөнхий техникийн тодорхойлолтыг хэрэглэх нь ихээхэн давуу талтай. Хэдийгээр тухайлсан ажлын гэрээнд заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч барилтын ажилд хамаарах онцлог шинж чанар, материал, тоног төхөөрөмжийн бүх ангиллыг ерөнхий техникийн тодорхойлолтод тусгах шаардлагатай. Тухайн ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ ерөнхий техникийн тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт хийх буюу шаардлагагүй зүйлийг түүнээс хасна.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материал, шинж чанарын талаарх техникийн тодорхойлолтын стандартад аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартыг хангах буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй. Дараах заалтыг гэрээний тусгай нөхцөлд, эсхүл техникийн тодорхойлолтод тусгаж болно.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ.

Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишигчийц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө.

*Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зориулсан эдгээр санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно.
Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулах шаардлагагүй.*

**ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР,
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

		Шалгур
Ойжуулалтын ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд		<p>"Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх" чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй байх.</p> <p>Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны тайланг гэрэл зургаар баталгаажуулах. Ойжуулалтын ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх. Маргажийн боловсон хүчиний диплом, мэргэжлийн үнэмлэх, ажилд орсон тушаал, хөдөлмөрийн гэрээ (тэдгээрийг баталгаажуулах) Удирдах болон инженер техникийн ажилтуудын мэдээлэл, мэдэгдэл.</p> <p>Ойжуулах ажилд швардлагдах шаардлага хангасан стандартын тарьцын неөцтэй байх. Стандартын швардлага хангасныг нотлох баримт, материалыг ируулэх.</p> <p>Сүүлийн 2 жилд хийсэн ойжуулалт болон адил төстэй ажлын үр дүн. (акт, гарзээний хувь, тайланг хавсарах)</p> <p>1 га талбайг ойжуулахад шилмүүст модны тарьц 2500-вас доошгүй байхаар тусгах огно.</p> <p>Ойжуулалтын ажилд шаардлагатай ажлын багаж, хэрэгслэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл түүнийг гэрэл зургаар баталгаажуулах. Автомашин түрээслэх гэрээ, үнэмлэх, баримт бичиг. Багаж тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт.</p> <p>Тарьц, суулгацын амьдралтыг дээшлүүлэх арга технологи, төвлөвлөлт.</p> <p>Ойжуулалтын ажил болон, таримал ойг арчлах хамгаалах, талаар захирлын болон ерөнхий инженерэрээ баталгаажуулсан технологийн карттай байх</p> <p>Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, ажлын төсөв. (баталгаажуулах)</p>
Бэлтгэл ажил		<p>Ойжуулах, мод тарих талаар орон нутгийн иргэдэд зориулсан сургалт сурталчилгааг өргөнөөр хийх, иргэдлийг татан оролцуулах.</p> <p>Ойжуулах ажлын технологийн картыг боловсруулж батлуулах.</p> <p>Ойжуулах талбайг тусгварлах, тэмдэглэх, өнцөгүүдэд шон босгох. Тусгаарласан талбайн захын цэгүүдийн солбицолыг GPS-ээр хэмжсэн байх.</p> <p>Ойжуулах талбайг цэвэрлэх, бэлтгэх, шан, талбар гаргах, чиг тэмдэг тавих.</p> <p>Суулгах материалыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим.</p>
Үндсэн ажил		<p>Завхан аймгийн Идэр сумын нутагт 28.7 га талбайд ойжуулалтын ажил хийнз.</p> <p>Тарих талбайн хөрс бэлдэх.</p> <p>Суулгах материалыг тарилтанд бэлдэх.</p> <p>Баталгаажуулсан технологийн картын дагуу тарилт хийх, услах, арчлан хамгаалах.</p>
Усалгаа, хамгаалалт, нохон тарилт хийх		<p>Ойжуулах талбайд тарилт хийхдээ бороо угтуулах, тарьсын дараах усалгааг заавал хийх талаар тусгах.</p> <p>Ургах чадваргүй бопсон тарьц, суулгацыг ухаж авах, нөхөн тарилт хийх талаар тусгах егэх.</p> <p>Таримал ургамлыг 3 жилийн туршид арчлах, гадны хучин зүйлзэс хамгаалах.</p> <p>Ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга самбар байрлуулах. (ойжуулсан талбайн хэмжээ, гүйцэтгэсэн ААН-ийн нэр, огноо зэргийг тусгасан байх)</p>
Тайлан боловсруулалтын ажил		<p>Ойжуулалтын ажлын тайланг захиалагчид 2% ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хасгатай байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ойжуулалтын ажлын бичмэл тайлан. 2. Ойжуулалт хийх үеийн гэрэл зургууд. 3. Ажилласан иргэдийн нээсний жагсаалт, регистрийн дугаарын жагсаалт 4. Ойжуулсан талбайн зураг, захын цэгүүдийн солбицлуудын хамт. (GPS-ээр хэмжсэн)
Ажил гүйцэтгэх төсөв		<p>Хорин сая төгрөг (20000000).</p> <p>1га талбайг ойжуулах норматив зардал зургаан зуун ерэн таван мянган төгрөг (695000).</p>

Боловсруулсан: Ойн албаны дарга  Д. Банзрагч

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтэд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гарана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- | | |
|---|--|
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |
|---|--|

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|--|
| 11. Үе шатны ажлын хуваарь | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p> |
| 13. Алданги | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнэ. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p> |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | |
|--------------------------|--|
| 14. Ажил дуусгах | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| 15. Хүлээж авах | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p> |
| 16. Эцсийн тооцоо | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хургуулнэ.</p> <p>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.</p> <p>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хургуулнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.</p> |

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага	<p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүй улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дунг суутгана.</p>
18. Гэрээг цуцлах	<p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буудсан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p>
19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	<p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>

- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ЗАВХАН АЙМАГИЙН ИДЭР СУМАНД “ОЙЖУУЛАЛТ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ” АЖИЛ Дугаар 09-ХА-12/2020
ГЕН 2.1	Ажил нь [ЗАВХАН АЙМАГИЙН ИДЭР СУМАНД “ОЙЖУУЛАЛТ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ” АЖИЛ]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь [Завхан аймаг Идэр сум]-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь Г.Цогзолмаа
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр [гэрээ хийгдсэн өдрөөс] Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [2020.05.01]
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [30.] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 365] хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.03 .] байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10%] –иас ихгүй байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [2020.....]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [2019.....]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [.....] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [. 0 .]-иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]